НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Хан-Уул дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтсийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** НТАГ-2026/504/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаанбаатар хот<br>2026 он | Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер: Х.Түвшинбаяр<br>Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn<br><br>Аудитын менежер: Д.Отгонбаяр<br>Утас: 315558 Цахим хаяг: otgonbayarda@audit.gov.mn<br><br>Аудитор: Т.Гандолгор<br>Утас: 325093 Цахим хаяг: gandolgort@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

# 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026.02.25 № 283

танай ______________-ны № ______________-т

НИЙСЛЭЛИЙН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ХҮҮХЭД, ГЭР БҮЛИЙН ХӨГЖИЛ, ХАМГААЛЛЫН ХЭЛТСИЙН ДАРГА М.ГАНБОЛД ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Хан-Уул дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтсийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар залруулагдаагүй 148,6 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон холбогдох хууль журамд нийцээгүй, санхүүгийн тайлагналын "эрх ба үүрэг", "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тус байгууллага нь “Түр хамгаалах байр”-ны хүнсний материалын зарцуулалт болон тус байранд үйлчилгээ авсан хүүхдүүдийн тоо, судалгааг үнэн зөв, бодитой гаргаагүй, дотоод хяналтын тогтолцоо сул байна.

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

1426050203

C:\Users\narangua.j\Desktop\Бичиг хэрэг 2026\2026\word\ywsan bichig\2026.02.25 Dugnelt - -.docx

**Аудитын гол асуудал**

Хүүхдийн зусланд амарсан, өвлийн хувцас олгосон, хүүхэд харах үйлчилгээнд хамрагдсан хүүхдүүдийн мэдээллийг able буюу https://intranet.gov.mn/ системийн мэдээллийн сантай тулган баталгаажуулах боломжгүй, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн мэдээллийг бүртгэх able буюу https://intranet.gov.mn/ системийн ажиллагаа доголдолтой, бүрэн ашиглахгүй байна.

**Бусад асуудал**

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тайлант онд 4 зорилтын хүрээнд 46 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлийг 95.3 хувийн хэрэгжилттэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Г.НАНДИНЖАРГАЛ

C:\Users\narangua.j\Desktop\Бичиг хэрэг 2026\2026\wordywsan bichig\2026.02.25 Dugnelt - -.docx

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **91,502,700.51** | **53,379,212.92** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 91,502,700.51 | 53,379,212.92 |
| **351** | **Түүхий эд материал** | **2,087,489.00** | **5,220,230.00** |
| 35130 | Эм боох материал | 2,087,489.00 | 5,220,230.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 89,415,211.51 | 48,158,982.92 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 2,477,800.00 | 668,130.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 4,039,475.40 | 243,424.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 738,370.00 | 2,558,370.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 2,023,800.00 | 7,496,300.00 |
| 35460 | Хүнсний материал | 949,052.31 | 5,375,177.12 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 79,186,713.80 | 31,817,581.80 |
| 2 | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,783,618,014.03** | **5,043,914,499.52** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,783,618,014.03 | 5,043,914,499.52 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,780,318,014.03 | 5,040,944,499.52 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 937,456,064.00 | 4,339,407,465.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -74,133,216.95 | -119,714,240.72 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 59,899,970.00 | 59,899,970.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -20,000,000.00 | -26,649,995.00 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 748,626,167.52 | 837,983,567.52 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -227,807,252.46 | -367,081,403.82 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 37,334,827.00 | 37,334,827.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -14,933,930.80 | -18,667,413.50 |
| 39217 | Ном | 47,490,282.00 | 47,490,282.00 |
| 39301 | Програм хангамж | 6,140,000.00 | 6,140,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -2,840,000.00 | -3,170,000.00 |
| 3 | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,875,120,714.54** | **5,097,293,712.44** |
| 5 | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,875,120,714.54** | **5,097,293,712.44** |
| 51 | **Засгийн газрын хувь оролцоо** | 1875120714.54 | 5,097,293,712.44 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 1,853,690,781.56 | 5,075,863,779.46 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,877,878,173.35 | 1,853,690,781.56 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | (24,187,391.79) | 3,222,172,997.90 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 21,429,932.98 | 21,429,932.98 |
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,875,120,714.54** | **5,097,293,712.44** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,479,425,925.00** | **6,513,008,632.26** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **100,698,270.00** | **3,539,348,676.26** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 100,698,270.00 | 3,539,348,676.26 |
| 120010 | Борлуулалтын орлого (цэвэр) /ТӨҮГ/ | 49,500.00 | 48,039,875.26 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого Үндсэн хөрөнгө | 99,973,970.00 | 3,491,308,801.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого -Бараа материал | 674,800.00 | |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,378,727,655.00** | **2,973,659,956.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,137,739,200.00 | 2,302,894,400.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,137,739,200.00 | 2,302,894,400.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 240,988,455.00 | 670,765,556.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 240,988,455.00 | 670,765,556.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,503,613,316.79** | **3,290,835,634.36** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,503,613,316.79** | **3,290,835,634.36** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,464,549,915.66 | 3,092,335,027.61 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 515,108,212.59 | 1,487,201,749.05 |
| 210101 | Үндсэн цалин | 299,362,389.21 | 845,477,529.44 |
| 210102 | Нэмэгдэл | 74,331,028.38 | 174,114,113.42 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 104,952,646.00 | 359,099,828.84 |
| 210104 | Урамшуулал | 36,462,149.00 | 108,510,277.35 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 63,981,100.00 | 188,714,751.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 43,331,200.00 | 128,258,611.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,162,400.00 | 15,121,448.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,581,200.00 | 7,555,736.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,581,300.00 | 7,555,736.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 10,325,000.00 | 30,223,220.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 4,742,500.63 | 50,142,064.62 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 158,192.98 | 38,727,230.85 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,601,667.25 | 9,163,515.93 |
| 210304 | Байрны түрээс | 982,640.40 | 2,251,317.84 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 54,337,098.00 | 113,120,456.72 |
| 210401 | Бичиг хэрэг | 19,708,090.00 | 31,182,877.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 25,460,000.00 | 29,675,500.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,794,199.00 | 11,597,657.32 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 400,000.00 | 0.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 63,000.00 | 20,425,000.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 6,911,809.00 | 15,412,030.40 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 0.00 | 4827392.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 20,076,524.58 | 95,055,096.12 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,874,512.00 | 12,398,099.00 |
| 210502 | Хоол, хүнс | 18,202,012.58 | 45,625,445.72 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 0.00 | 37,031,551.40 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 10,000.00 | 10,897,900.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 10,000.00 | 0.00 |
| 210604 | Урсгал засвар | 0.00 | 10,897,900.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 620,467,061.11 | 913,356,034.59 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 620,467,061.11 | 908,900,109.59 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 0.00 | 4,455,925.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 185,827,418.75 | 233,846,975.51 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 0.00 | 2,834,660.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 185,827,418.75 | 231,012,315.51 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 39,063,401.13 | 198,500,606.75 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 8,545,259.00 | 52,164,000.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 358,399.00 | 0.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 7,286,860.00 | 0.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 900,000.00 | 52,164,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 30,518,142.13 | 146,336,606.75 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 30,518,142.13 | 146,336,606.75 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-24,187,391.79** | **3,222,172,997.90** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(24,187,391.79)** | **3,222,172,997.90** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,378,777,155.00** | **3,021,699,831.26** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **49,500.00** | **48,039,875.26** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 49,500.00 | 48,039,875.26 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 49,500.00 | 48,039,875.26 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 49,500.00 | 48,039,875.26 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,378,727,655.00** | **2,973,659,956.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,137,739,200.00 | 2,302,,894,400.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,137,739,200.00 | 2,302,894,400.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 240,988,455.00 | 670,765,556.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 240,988,455.00 | 670,765,556.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,355,277,155.00** | **3,021,699,831.26** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,355,277,155.00** | **3,021,699,831.26** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,316,572,152.87** | **2,823,199,224.51** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 514,301,373.64 | 1,487,201,749.05 |
| 210101 | Үндсэн цалин | 299,155,550.26 | 845,477,529.44 |
| 210102 | Нэмэгдэл | 73,731,028.38 | 174,114,113.42 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 104,952,646.00 | 359,099,828.84 |
| 210104 | Урамшуулал | 36,462,149.00 | 108,510,277.35 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 64,531,100.00 | 188,704,751.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 43,881,200.00 | 128,258,611.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,162,400.00 | 15,111,448.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,581,200.00 | 7,555,736.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,581,300.00 | 7,555,736.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 10,325,000.00 | 30,223,220.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 4,988,005.23 | 50,142,064.62 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 158,192.98 | 38,727,230.85 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,847,171.85 | 9,163,515.93 |
| 210304 | Байрны түрээс | 982,640.40 | 2,251,317.84 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 8,531,491.00 | 55,813,997.32 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,880,190.00 | 13,263,790.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,289,840.00 | 27,950,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,801,899.00 | 11,597,657.32 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,779,200.00 | 4,052,750.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 0.00 | 102,347,862.38 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 0.00 | 1,553,0840.00 |
| 210502 | Хоол, хүнс | 0.00 | 73,152,722.38 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 0.00 | 13,664,300.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 0.00 | 13,713,400.00 |
| 210604 | Урсгал засвар | 0.00 | 13,713,400.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 724,220,183.00 | 912,011,993.14 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 724,220,183.00 | 907,556,068.14 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 0.00 | 4,455,925.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 0.00 | 13,263,407.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 0.00 | 13,263,407.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **38,705,002.13** | **198,500,606.75** |

| | | | |
|---|---|---|---|
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 8,186,860.00 | 52,164,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 8,186,860.00 | 52,164,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **30,518,142.13** | **146,336,606.75** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 30,518,142.13 | 146,336,606.75 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **23,500,000.00** | **0.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **23,500,000.00** | **0.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **235,000,00.00** | **0.00** |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 23,500,000.00 | 0.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 23,500,000.00 | 0.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-23,500,000.00** | **0.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 0.00 | 0.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 49,500.00 | 48,039,875.26 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 0.00 | 21,934,064.00 | 1,025,352,191.42 | 0.00 | 1,047,286,255.42 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 3,000.00 | 0.00 | 0.00 | 3,000.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **0.00** | **21,937,064.00** | **1,025,352,191.42** | **0.00** | **1,047,289,255.42** |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 0.00 | -507,131.02 | 0.00 | 0.00 | -507,131.02 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний  бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 852,525,981.93 | 0.00 | 852,525,981.93 |
| C08 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **0.00** | **21,429,932.98** | **1,853,690,781.56** | **0.00** | **1,875,120,714.54** |
| D01 | **2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **0.00** | **21,429,932.98** | **1,853,690,781.56** | **0.00** | **1,875,120,714.54** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **0.00** | **21,429,932.98** | **1,853,690,781.56** | **0.00** | **1,875,120,714.54** |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт,  бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 3,222,172,997.90 | 0.00 | 3,222,172,997.90 |
| D09 | **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 0.00 | 21,934,064.00 | 1,025,352,191.42 | 0.00 | 1,047,286,255.42 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **2,314,449,300.00** | **2,194,898,902.02** | **119,550,397.98** | **94.8%** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,314,449,300.00** | **2,194,898,902.02** | **119,550,397.98** | **94.8%** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,257,434,300.00** | **2,142,734,902.02** | **114,699,397.98** | **94.9%** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,192,840,900.00 | 1,191,470,605.45 | 1,370,294.55 | 99.9% |
| 210101 | Үндсэн цалин | 692,734,200.00 | 683,045,852.84 | 9,688,347.16 | 98.6% |
| 210102 | Нэмэгдэл | 110,736,400.00 | 127,546,913.40 | -16,810,513.40 | 115.2% |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 291,614,200.00 | 291,938,332.86 | -324,132.86 | 100.1% |
| 210104 | Урамшуулал | 97,756,100.00 | 88,939,506.35 | 8,816,593.65 | 91.0% |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 150,799,000.00 | 150,798,995.00 | 5.00 | 100.0% |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 102,482,700.00 | 102,482,695.00 | 5.00 | 100.0% |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 12,078,900.00 | 12,079,000.00 | -100.00 | 100.0% |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,039,500.00 | 6,039,500.00 | 0.00 | 100.0% |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 6,039,600.00 | 6,039,500.00 | 100.00 | 100.0% |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 24,158,300.00 | 24,158,300.00 | 0.00 | 100.0% |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 44,587,300.00 | 25,916,474.73 | 18,670,825.27 | 58.1% |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 16,485,600.00 | 15,992,371.02 | 493,228.98 | 97.0% |
| 210302 | Түлш, халаалт | 25,277,900.00 | 8,571,191.77 | 16,706,708.23 | 33.9% |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,823,800.00 | 1,352,911.94 | 1,470,888.06 | 47.9% |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 54,331,100.00 | 47,175,049.32 | 7,156,050.68 | 86.8% |
| 210401 | Бичиг хэрэг | 11,423,100.00 | 10,535,558.00 | 887,542.00 | 92.2% |
| 210402 | Тээвэр, шатахуун | 27,408,000.00 | 25,520,000.00 | 1,888,000.00 | 93.1% |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 9,189,500.00 | 8,116,941.32 | 1,072,558.68 | 88.3% |
| 210404 | Ном, хэвлэл | 54,331,100.00 | 47,175,049.32 | 7,156,050.68 | 86.8% |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,075,900.00 | 0.00 | 1,075,900.00 | 0.0% |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,234,600.00 | 3,002,550.00 | 2,232,050.00 | 57.4% |
| **2105** | **Нормативт зардал** | 18,542,000.00 | 14,678,670.38 | 3,863,329.62 | 79.2% |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,077,300.00 | 810,000.00 | 267,300.00 | 75.2% |
| 210502 | Хоол, хүнс | 0.00 | 204,370.38 | -204,370.38 | |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 17,464,700.00 | 13,664,300.00 | 3,800,400.00 | 78.2% |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 4,716,500.00 | 4,716,500.00 | 0.00 | 100.0% |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 4,716,500.00 | 0.00 | 4,716,500.00 | 0.0% |
| 210604 | Урсгал засвар | 0.00 | 4,716,500.00 | -4,716,500.00 | |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 4,488,600.00 | 0.00 | 4,488,600.00 | 0.0% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210702 | Дотоод албан томилолт | 4,488,600.00 | 0.00 | 4,488,600.00 | 0.0% |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 773,809,400.00 | 694,715,200.14 | 79,094,199.86 | 89.8% |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 767,589,800.00 | 690,259,275.14 | 77,330,524.86 | 89.9% |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | | | | |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 447,900.00 | 0.00 | 447,900.00 | 0.0% |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 89,600.00 | 0.00 | 89,600.00 | 0.0% |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 44,800.00 | 0.00 | 44,800.00 | 0.0% |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 5,637,300.00 | 4,455,925.00 | 1,181,375.00 | 79.0% |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **13,319,500.00** | **13,263,407.00** | **56,093.00** | **99.6%** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 13,319,500.00 | 13,263,407.00 | 56,093.00 | 99.6% |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **57,015,000.00** | **52,164,000.00** | **4,851,000.00** | **91.5%** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 57,015,000.00 | 52,164,000.00 | 4,851,000.00 | 91.5% |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 57,015,000.00 | 52,164,000.00 | 4,851,000.00 | 91.5% |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **2,314,449,300.00** | **2,194,898,902.02** | **119,550.397.98** | **94.8%** |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **2,314,449,300.00** | **2,194,759,026.76** | **119,690,273.24** | **94.8%** |
| 132001 | Улсын төсвөөс санхүүжих | **2,314,449,300.00** | **2,194,759,026.76** | **119,690,273.24** | **94.8%** |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | | 139,875.26 | (139,875.26) | |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | 139,875.26 | (139,875.26) | |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 680,464,322.49 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 680,464,322.49 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 680,464,322.49 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 295,731,143.60 |
| 210101 | Үндсэн цалин | 162,431,676.60 |
| 210102 | Нэмэгдэл | 46,567,200.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 67,161,496.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 37,905,756.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 25,775,916.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,032,448.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,516,236.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,516,236.00 |

| | | |
|---|---|---|
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,064,920.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 24,225,589.89 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 22,734,859.83 |
| 210302 | Түлш, халаалт | 592,324.16 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 898,405.90 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 863,8948.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,728,232.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,430,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,480,716.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 87669192.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 14,720,840.00 |
| 210502 | Хоол, хүнс | 72,948,352.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 8,996,900.00 |
| 210604 | Урсгал засвар | 8,996,900.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 217,296,793.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 217,296,793.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 718,665,556.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 670,765,556.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 670,765,556.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 47,900,000.00 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 148,579.3 мянган төгрөгийн зөрчил[1] илэрснээс, 7,766.8 мянган төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоож, 31,560.00 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 109,252.5 мянган төгрөгийн зөрчилд 8 зөвлөмж өгсөн.

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Төсвийн гүйцэтгэлийн тайланд батлагдсан төсвийн санхүүжүүлэх 2,973,660.0 мянган төгрөгийн эх үүсвэр болон зарцуулалтыг тусгаагүй байна; | 1 | 2,973,660.0 | 1 | 2,973,660.0 | | | 1 | 2,973,660.0 | | | | |
| Бараа материалыг шууд зардлаар бүртгэсэнг | 1 | 13,907.5 | | | 1 | 13,907.5 | 1 | 13,907.5 | | | | |
| | **2** | **2,987,567.5** | 1 | 2,973,660.0 | 1 | 13,907.5 | **2** | **2,987,567.5** | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Жилийн эцсийн хөрөнгийн тооллогоор биетээр байхгүй хөрөнгийг тоолж тооллогыг чанаргүй хийсэн байна. | 1 | 20,000.0 | | | 1 | 20,000.0 | | | | | | |
| Хэлтсийн даргын 2025 оны А/24 дүгээр тушаалаар дарга өөрийнхөө орон тоог баталсан байна. | | | | | | | 1 | | | | | |
| Үндсэн хөрөнгийн үлдэгдэлд түүвэр тооллого хийхэд 2,158.0 мянган төгрөгийн хөрөнгө дутсан | 1 | 2,158.0 | 1 | 2,158.0 | | | | | | | | |
| Түр хамгаалах байрны хүнсний материалыг орлогод бүртгэсэн тухайн өдөртөө зарлагаар бүртгэсэн. Тус байранд үйлчилгээ авсан хүүхдүүдийн тоог үнэн зөв гаргаагүй, зөрүүтэй илэрхийлдэг. дотоод хяналт сул байна. | 1 | 42,991.8 | | | | | 1 | 42,991.8 | | | | |
| Үлдэх өртөггүй хөнгийн талаар өмч хамгаалах байнгын зөвлөлөөр хэлэлцэж шийдвэр гаргаагүй байна. | 1 | | | | | | 1 | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Байгууллагын хөрөнгөд бүртгэлтэй хуучин байр /ашигладаггүй/ -ны газар нь дүүргийн ЗДТГ-т бүртгэлтэй байна. | 1 | 15,525.2 | | | | | 1 | 15,525.2 | | | | |
| Архивын ажилтанд монгол бичгээр зохион бүрдүүлсэн баримт бичгийг хянан найруулах гэсэн бүтцэд байхгүй ажлыг хавсарган 40% -ийн нэмэгдлийг байгууллагын даргын 2025 оны Б/41 дүгээр тушаал гарган олгосон байна. | 1 | 4,618.8 | 1 | 4,618.8 | | | | | | | | |
| Анхан шатны баримтийн бүрдэл дутуу контентийг орлогод авсан | 1 | 13,300.0 | | | | | 1 | 13,300.0 | | | | |
| Анхан шатны баримтын бүрдэл дутуу зарлагын баримт үйлдээгүй, шаардах хуудас хавсаргаж бараа материал зарлагадаж бүртгэсэн байна. | 1 | | | | 1 | | | | | | | |
| Нийгмийн ажилтнуудыг чиглүүлэх сургалт зохион байгуулахад хоолны мөнгө давхардуулан 990.00 мянган төгрөгийг зарцуулсан байна. | 1 | 990.0 | 1 | 990.0 | | | | | | | | |
| Шатахууны зарцуулалтын тайлан, жолоочийн тооцооны хуудасгүй шатахуун зарлага болгосон дотоод хяналт сул байна. | 1 | 37,435.5 | | | | | 1 | 37,435.5 | | | | |
| Нөөцлөх шаардлагагүй 3 төрлийн бараа материалыг их хэмжээгээр бэлтгэсэн байна. | 1 | 11,560.0 | | | 1 | 11,560.0 | | | | | | |
| **Дүн** | **12** | **148,579.3** | **3** | **7,766.8** | **3** | **31,560.00** | **6** | **109,252.5** | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Хүүхдийн зусланд амарсан, өвлийн хувцас олгосон, хүүхэд харах үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн мэдээллийг able буюу https://intranet.gov.mn/ системийн мэдээллийн сантай тулган баталгаажуулах боломжгүй байна. Эрсдэлт нөхцөл байгаа хүүхдийн мэдээллийг бүртгэх able буюу https://intranet.gov.mn/ системийн ажиллагаа доголдолтой, бүрэн ашиглахгүй байна. | 1 | | | | | | 1 | |
| **Дүн** | **1** | | | | | | **1** | |

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АКТ

2026 оны 02 дугаар сарын 25 № 20/А027344 Улаанбаатар хот

НТАГ-2026/504/НА-СТА-ТШЗ

## Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Хан-Уул дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтсийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Үндсэн хөрөнгийн үлдэгдэлд түүвэр тооллого хийхэд 2,158,000.0 (хоёр сая нэг зуун тавин найман мянга) төгрөгийн хөрөнгө дутсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "*эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах*",Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д *"батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"*, Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалын холбогдох заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.2-т "*Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана.*" гэж заасантай нийцэхгүй

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.7-т "төрийн болон орон нутгийн өмч, хөрөнгийг дутаасан, үрэгдүүлсэн хууль бусаар ашигласан" гэсэн заалтыг тус тус үндэслэн **ТОГТООХ нь**:

1.Нийслэлийн Хан-Уул дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтсийн илэрсэн зөрчлийн 2,158,000.0 (хоёр сая нэг зуун тавин найман мянга) төгрөгийг Нийслэл дэх Төрийн аудитын газрын Төрийн сан банкин дахь НТАГ.хүү торгуулийн орлогын IBAN440090100200000908 дугаар дансанд төвлөрүүлэх;

2.Актын биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэхийг Хан-Уул дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтсийн дарга М.Ганболд, нягтлан бодогч Д.Дарьсүрэн нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

| | |
|---|---|
| ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР | Г.НАНДИНЖАРГАЛ |
| АУДИТЫН МЕНЕЖЕР | Д.ОТГОНБАЯР |
| АУДИТОР | Т.ГАНДОЛГОР |

---

[1] Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар

1426110074

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
**АКТ**

2026 оны 02 дугаар сарын 23 № 31/A0273 44 Улаанбаатар хот

НТАГ-2026/504/НА-СТА-ТШЗ

**Төлбөр барагдуулах тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Хан-Уул дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтсийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нийгмийн ажилтнуудыг чиглүүлэх сургалт зохион байгуулах үед хоолны зардлыг давхардуулан 990,000.0 (есөн зуун ерэн мянга) төгрөг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалын холбогдох заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.5-д "бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн" заалтад заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1.Нийслэлийн Хан-Уул дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтсийн илэрсэн зөрчлийн 990,000.0 (есөн зуун ерэн мянга) төгрөгийг Нийслэл дэх Төрийн аудитын газрын Төрийн сан банкин дахь НТАГ.хүү торгуулийн орлогын IBAN440090100200000908 дугаар дансанд төвлөрүүлэх;

2.Актын биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэхийг Хан-Уул дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтсийн дарга М.Ганболд, нягтлан бодогч Д.Дарьсүрэн нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Г.НАНДИНЖАРГАЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР Д.ОТГОНБАЯР

АУДИТОР Т.ГАНДОЛГОР

---

[1] Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар

1426110071

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**АКТ**

2026 оны 02 дугаар сарын 25 № 30/A023374 Улаанбаатар хот

НТАГ-2026/504/НА-СТА-7Ш3

**Төлбөр барагдуулах тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Хан-Уул дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтсийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын даргын 2025 оны Б/41 дүгээр тушаалаар архивын ажилтанд байгууллагын бүтэц, орон тоонд батлаагүй “монгол бичгээр зохион бүрдүүлсэн баримт бичгийг хянан найруулах” гэх ажлыг хавсарган 40 хувийн нэмэгдэл 4,618,000.0 (дөрвөн сая зургаан зуун арван найман мянга) төгрөгийн цалинг олгосон байна

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-д "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно." /тогтоосон шийдвэр/ гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.6-д “эрх бүхий этгээдээс тогтоосон норм, нормативыг хэтрүүлэн зарцуулсан” заалтыг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1.Нийслэлийн Хан-Уул дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтсийн илэрсэн зөрчлийн 4,618,000.0 (дөрвөн сая зургаан зуун арван найман мянга) төгрөгийг Нийслэл дэх Төрийн аудитын газрын Төрийн сан банкин дахь НТАГ.хүү торгуулийн орлогын IBAN440090100200000908 дугаар дансанд төвлөрүүлэх;

2.Актын биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэхийг Хан-Уул дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтсийн дарга М.Ганболд, нягтлан бодогч Д.Дарьсүрэн нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Г.НАНДИНЖАРГАЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР Д.ОТГОНБАЯР

АУДИТОР Т.ГАНДОЛГОР

---

[1] Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар

1426110069

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 945/А007344 Улаанбаатар хот

НТАГ-2026/504/НА-СТА-ТШЗ

**Зөрчил арилгах тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Хан-Уул дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтсийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нөөцлөх шаардлагагүй 3 төрлийн бараа материалыг бодит хэрэгцээ, зарцуулалтын төлөвлөгөөнд үндэслэлгүйгээр их хэмжээгээр бэлтгэн нөөцөлсөн байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д *"Нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх"* гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын *"нийцсэн бөгөөд зохистой байх"* батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д *"Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө"*, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан *"Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"*-ын 4.2.1.11-д *"хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"* заалтыг тус тус үндэслэн **ШААРДАХ нь**:

1.Нөөцлөх шаардлагагүй 3 төрлийн бараа материалыг бодит хэрэгцээ, зарцуулалтын төлөвлөгөөнд үндэслэлгүйгээр их хэмжээгээр бэлтгэн нөөцөлсөн зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх, биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн Хан-Уул дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтсийн М.Ганболд, нягтлан бодогч Д.Дарьсүрэн нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Г.НАНДИНЖАРГАЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР Д.ОТГОНБАЯР

АУДИТОР Т.ГАНДОЛГОР

---

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар

1426090241

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 142/А007344 Улаанбаатар хот

НТАГ-2026/504/НА-СТА-ТШЗ

**Зөрчил арилгах тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Хан-Уул дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтсийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Жилийн эцсийн хөрөнгийн тооллогоор биетээр байхгүй хөрөнгийг тооллогод хамруулсан нь тооллогыг бодитой, чанартай зохион байгуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.2-т "Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана." гэж заасантай нийцэхгүй

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д *"Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө"*, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан *"Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"*-ын 4.2.1.2-т *"хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хийгээгүй, баримтжуулаагүй, баталгаажуулаагүй"* заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Жилийн эцсийн хөрөнгийн тооллогоор биетээр байхгүй хөрөнгийг тооллогод хамруулж, тооллогыг үнэн зөв, чанартай хийгээгүй зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх, биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн Хан-Уул дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтсийн М.Ганболд, нягтлан бодогч Д.Дарьсүрэн нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Г.НАНДИНЖАРГАЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР Д.ОТГОНБАЯР

АУДИТОР Т.ГАНДОЛГОР

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар

1426090239

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 05 өдөр Дугаар 169/А0273НН Улаанбаатар хот

НТАГ-2026/504/НА-СТА-ТШЗ

**Зөрчил арилгах тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Хан-Уул дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтсийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бараа, материалын зарлагын баримт үйлдээгүй, шаардах хуудас хавсаргаж бараа материал зарлагдсан, анхан шатны баримтын бүрдэл дутуу гүйлгээ бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "*Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална*, 5.1.4-д "*үнэн зөв байх*", 13.7-д "*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*", 20 дугаар зүйлийн 20.1.4-д "*хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх*" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д *"Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө"*, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан *"Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"*-ын 4.2.1.1-д *"нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй"* заалтыг үндэслэн **ШААРДАХ нь**:

1.Анхан шатны баримтын бүрдэл дутуу, зарлагын баримт үйлдээгүй, шаардах хуудас хавсаргаж бараа материал зарлагдаж бүртгэсэн зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх, биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн Хан-Уул дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтсийн М.Ганболд, нягтлан бодогч Д.Дарьсүрэн нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Г.НАНДИНЖАРГАЛ
АУДИТЫН МЕНЕЖЕР Д.ОТГОНБАЯР
АУДИТОР Т.ГАНДОЛГОР

---

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар

1426090307